



Title	МИНЬХЭ МОНГОР ХЭЛЭН ДЭХ ИДЭЭ УНДААНЫ ЗАРИМ НЭРИЙН АВИА, УТГЫН ХУВЬСЛЫН ТУХАЙ
Author(s)	塩谷, 茂樹
Citation	外国語教育のフロンティア. 2024, 7, p. 11-27
Version Type	VoR
URL	https://doi.org/10.18910/94980
rights	
Note	

The University of Osaka Institutional Knowledge Archive : OUKA

<https://ir.library.osaka-u.ac.jp/>

The University of Osaka

МИНЬХЭ МОНГОР ХЭЛЭН ДЭХ ИДЭЭ УНДААНЫ ЗАРИМ НЭРИЙН АВИА, УТГЫН ХУВЬСЛЫН ТУХАЙ

On the Phonetic and Semantic Changes of Some Food and Drink Names in the Minhe Monguor Language

(民和土族語における若干の飲食物名の音声・意味変化について)

塩谷 茂樹

Abstract

The Minhe Monguor language belongs to the Mongolic languages and is spoken in Guanting town in the southeast of Minhe Hui and Tu Autonomous County, Qinghai province, China.

There are several words in this language that are quite different phonetically and semantically compared to Modern Mongolian, so the discussion in this paper will focus on the names of food and drink.

The research method used in this paper is to compare words of the Minhe Monguor language with those of Written Mongolian, Middle Mongolian and Modern Mongolian from a diachronic perspective.

As a result of the research, the phonetic changes of words such as *dimei* < MMo. *üdmeg* “bread”, *puzuoghuo* < Mo. *boyursuγ* “fried piece of dough”, *mugha* < *maqa* < Mo. *miqa* “meat”, *jierghasi* < *jilyasun* < *jīyalsun* > Mo. *jīyasun* “fish”, *ghuru* < *yuril* < Mo. *γulir* “flour”, *budi* < Mo. *buyudai* “wheat” and *suzu* < Mo. *usu* “water” etc. are first mentioned, and then the semantic changes of words such as *yama* “food < thing”, *buda* “noodles < grain”, *amula* “fruit < apple, pear” and *durasi* “liquor” (> Mo. *darasu* “wine”) etc. are also explained.

In conclusion, as phonetic changes, elision of word-initial vowels and word-final consonants, shortening or diphthongization of long vowels, devoicing of word-initial consonants, voicing of second syllable initial consonants, metathesis, and retention of old sound *r* (< **l*) were observed; as semantic changes, narrowing (specialization, or restriction of meaning) and broadening (generalization, or extension of meaning) were found through this study.

キーワード：民和土族語、飲食物名、音声変化、意味変化

Түлхүүр үг: Миньхэ монгол хэл, идээ ундааны нэр, авианы хувьсал, утгын хувьсал

Эхлэл

Миньхэ монгол хэл бол Хятадын Цинхай мужийн Миньхэ хотон монгол үндэстний өөртөө засах шяний Гуантин балгасны монголчуудын ярьдаг хэл бөгөөд монголчууд нь түүхэндээ бичиг үсэг хэрэглэж байсангүй. Одоогоор тус хэлээр хэлэлцэгч 10.000 гаруй хүн байна гэсэн тооцоо бий.

Миньхэ монгол хэлний талаар Б.Х.Тодаева (1973), Dpal-ldan-bkra-shis, Keith W.Slater

нар (1996), Jiang Genxiong (2018), Keith W.Slater (2003a,b) зэрэг судлаачийн ном бүтээл, өгүүлэл гарч, одоогийн Миньхэ монгол хэлний төлөв байдлыг зохих хэмжээгээр товчоолон дурдсан байдаг. Гэвч алинд нь ч тус хэлний үгзүй ба үгсийн сангийн талаар бараг судлаагүй гэж болохоор байна.

Тус өгүүлэлдээ бид Миньхэ монгол хэлэн дэх идээ ундааны зарим нэрийг тусгайлан авч үзэхдээ тэдгээрийн хэлний авиа, утгын хувьслын талаар тодорхойлохыг зорилоо.

Авианы хувьслын үүднээс: *dimei* “bread”, *puzuoghuo* “fried piece of dough”, *tugha* “meat”, *jierghasi* “fish”, *ghuru* “flour”, *budi* “wheat”, *suzu* “water” гэх мэт үгийг, утгын хувьслын үүднээс: *yama* “food”, *buda* “noodles”, *amula* “fruit”, *durasi* “liquor” гэх мэт үгийг авч үзсэн болно.

1. Авианы хувьслын үүднээс үзэх нь

Миньхэ монгол хэлний идээ ундааны зарим нэрийг авианы хувьслын үүднээс авч үзье.

1.1 *dimei* [dimeɪ] “bread” (Kh. -, Mo. -)¹⁾

Миньхэ монгол хэлний энэхүү үг нь “мантуу зэрэг талхны зүйл” гэсэн утгатай бөгөөд үүнд таарахуйц үг монгол бичгийн хэл болон халхын аялгуунд байхгүй юм.

Тус үгийн хамгийн эртний үл мөр нь дундад үеийн монгол хэлний сурвалж бичиг “монгол хятад хэлний үгийн толь” болох *Чжи Юань и юй* (至元譯語, 1325)-д 兀都麻 *uduma* 《燒餅》, *Хуа-И и юй* (華夷譯語, 1389)-д 兀陽蔑克 *üdmeg* 《燒餅》 гэсэн хэлбэрээр тохиолдож байна. *Чжи Юань и юй* нь тухайн үеийн монгол хэлний үгийн дуудлагыг хятад үсгээр бүрэн гүйцэд тусгаж чадаагүй онцлогтой²⁾ учир *Хуа-И и юй* дээрх *üdmeg* гэдэг нь тухайн үеийн зөв дуудлага байсан гэж үзэж болно.

Авианы хувьслын үүднээс үзэхэд уг үг Миньхэ монгол хэлэнд дундад үеэс эдүгээ хүрэхдээ доорх мэтээр хувирч иржээ.

Үүнд: *üdmeg* (① үгийн төгсгөлийн гийгүүлэгч -g гээгдсэн) > **üdmē* (② үгийн битүү үе нь задгай үе болсон) > **üdmē* (③ үгийн эхний эгшиг *ü*- гээгдэж, ④ үгийн төгсгөлийн богино эгшиг -e нь хос эгшиг -ei болсон) > *dimei* [dimeɪ]

Энэ явцад тохиолдсон авианы үзэгдлийг үүссэн дарааллаар товчхон тайлбарлавал:

① Монгол бичгийн хэлний үе буюу үгийн адагт орсон гийгүүлэгч, өөрөөр хэлбэл хатуу дэвсгэр -y, -g нь Миньхэ монгол хэлэнд ихэнхдээ бүрэн гээгдэх дүрэмтэй байдаг. Энэ нь монгол бичгийн хэлний үгийн битүү үе нь Миньхэ монгол хэлэнд ер нь задгай үе болдог хандлагатай холбоотой юм.

Үүнд: #...CV_· / -y, -g > Ø

Жишээ нь:

/ khamu [qamu] (Mo. qamuɣ, Kh. хамар), suoduo- [suoduo-] (Mo. soɣtu-, Kh. согто-), wuruo [uruo] (Mo. uruɣ, Kh. урар) гэх мэт.

/ boduo [boduo] (Mo. ebüdüg, Kh. өвдөг), kheri [qəri] (Mo. kereg, Kh. хэрэг), tuoguori [tuoguori] “дугуй” (Mo. tögürig, Kh. төгрөг) гэх мэт.

② Монгол бичгийн хэлний үгийн битүү үе нь Миньхэ монгол хэлэнд ер нь задгай үе болох хандлагатай байна. Битүү үеийг задгай үе болгоход үе хааж битүүлдэг гийгүүлэгч (дэвсгэр үсэг) дээр эгшиг нэмэгдэх нэг арга зам бий.

Үүнд: # (C)VC·> # (C)V·CY·

Жишээ нь:

bosi- [bosi-] (Mo. bos-, Kh. бос-), chudu- [tʃudu-] (Mo. čad-, Kh. цад-) гэх мэт.

③ Миньхэ монгол хэлний үгийн өргөлт нь ямагт үгийн төгсгөлийн үед байдагтай холбогдуулан үгийн эхний эгшиг гээгдэх үзэгдэл нэлээн элбэг тохиолдож байна.

Жишээ нь:

ni [ni] (Mo. e·ne, Kh. энэ), ge [gə] (Mo. ü·ge, Kh. үг), duer [duə] (Mo. e·dür, Kh. өдөр), di- [di-] (Mo. i·de-, Kh. идэ-), xi- [ei-] (Mo. (h)e·ci-, Kh. очи-) гэх мэт.

④ Монгол бичгийн хэлний үгийн эхний үе юм уу, хоёрдугаар үеийн -е- эгшиг нь Миньхэ монгол хэлэнд голдуу хос эгшиг -ie- [-iə-], хааяа -ei- [-ei-] болох нь олонтоо бөгөөд ер нь *e > ie (~ ei) болох зарчимтай гэж болно.

Үгийн нэгдүгээр үед орсон -ie-гийн жишээнээс:

tierge [tiəgə] (Mo. terge, Kh. тэрэг), diere [diəra] (Mo. der-e, Kh. дэр), niere [niəra] (Mo. ner-e, Kh. нэр) гэх мэт.

Үгийн нэгдүгээр үед орсон -ei-гийн жишээнээс:

meidie- [meidie-] (Mo. mede-, Kh. мэдэ-), geigan [geigan] (Mo. gegen, Kh. гэгээн) гэх мэт.

Үгийн хоёрдугаар үед орсон -ie-гийн жишээнээс:


kelie [kəliə] “эрхтэн” (Mo. kele, Kh. хэл), gediesi [gədiəsi] (Mo. gedesü, Kh. гэдэс), weilie [wəiliə] (Mo. üile, Kh. үйл) гэх мэт.

Тус үгийн гарал үүслийг нь хөөж үзвэл түрэг хэлний *ekmek* “bread (талх)” (< *ek*- “sow (тарь-)”) гэсэн үгээс үүссэн боломж их байгаа бөгөөд Tur.³⁾ *ekmek* > ММо.⁴⁾ *üdmeg* [ütme] > Kalm.⁵⁾ өдмг [ödmg] “bread (талх)” гэх зэргээр дамжиж ирсэн байх гэж таамаглаж байна.

Улмаар монгол төрөл хэлний хүрээнд авч үзвэл дундад үеийн монгол хэл, халимаг хэл, Миньхэ монгол хэлнээс гадна Баоань хэл, Хүжү монгол хэл, Дагуур хэлэнд ч гэсэн энэ үгийн ул мөр нь харагдаж байна. Тухайлбал: Баоань хэл: *šdemə* “талх”, Хүжү монгол хэл: *šdima* “талх”, Дагуур хэл: *utum* “snack, biscuit (жигнэмэг)” гэх мэт.

Тус үгийн авианы хувьслыг хураангуйлж доор үзүүлэв.

Үүнд: Tur. *ekmek* “bread (талх)” → Mong.⁶⁾ *üdmeg* > **üdmə* > **üdmə*



1.2 puzuoghuo [puɖzuoguo] “fried piece of dough” (Kh. боорцог, Mo. boγursuy)

Миньхэ монгол хэлний энэхүү үг нь “тосонд хайрсан гурилан боов” гэсэн утгатай боорцог гэсэн үг юм.

Тус үг нь авианы хувьслын үүднээс дараах байдлаар хувирч ирсэн гэж үзэж байна.

Үүнд: *boγursay > boorsog (① урт эгшиг -oo нь богино эгшиг -o болсон) > borsog (② үеийн төгсгөлийн -r гээгдэж, ③ үгийн эхний b- нь p- болсон) > posog (④ үгийн хоёрдугаар үеийн -s нь -z болсон) > rozog (⑤ үгийн нэгдүгээр үеийн -o- нь -u- болсон ба ⑥ үгийн битүү үе нь задгай үе болсон) > puzuoghuo [puɖzuoguo]

Энэ явцад тохиолдсон авианы үзэгдлийг үүссэн дарааллаар товчхон тайлбарлая.

① Орчин цагийн монгол хэлний урт эгшиг нь Миньхэ монгол хэлэнд голдуу богино эгшиг, хааяа хос эгшигтэй тохиролцдог бөгөөд цуваа цагийн үүднээс үзэхэд Миньхэ монгол хэлэнд урт эгшиг нь богиносож, урт богино эгшгийн ялгаа байхгүй болсон байна.

Жишээ нь:

bosi [bosɪ] (1. Kh. бөөс, Mo. bögesü, 2. Kh. бөс, Mo. bös), khura [qura] (1. Kh. хур “бороо”, Mo. qur-a, 2. Kh. хураа-, Mo. quriya-), wula [ula] (Kh. уул, Mo. аұла) гэх мэт.

② Монгол бичгийн хэлний үе буюу үгийн адагт орсон гийгүүлэгч, өөрөөр хэлбэл хатуу дэвсгэр -r нь Миньхэ монгол хэлэнд ихэнхдээ бүрэн гээгдэх дүрэмтэй байдаг.

Үүнд: #...CV_ · / -r > Ø

Жишээ нь:

berqie [bæɬɕiə] (Mo. belčiger, Kh. бэлчээр), kezhi- [kædzɪ-] (Mo. kerči-, Kh. хэрчи-) гэх мэт.

③ Үгийн эхний зарим дуутай гийгүүлэгч нь хоёрдугаар үеийн эхний дуугүй гийгүүлэгчийн өмнө орохдоо авиа ижилших ёсоор дуугүй болсон байна.

Үүнд: b- > p [p]- / #_V·C₂ ([- voiced]) V·

Жишээ нь:

pijighe [pidʒigə] “үсэг” (Mo. bičig, Kh. бичиг), pughang [puɣaŋ] (Mo. burqan, Kh. бурхан), puzhi [puɖʒi] (Mo. bisi, Kh. биш), puza [puɖʒa] (Mo. basa, Kh. бас), pudu- [pudu-] (Mo. bütü-, Kh. бүтэ-), puzher- [puɖʒə-] (Mo. bučal-, Kh. буцал-) гэх мэт.

④ Үгийн хоёрдугаар үеийн эхний дуугүй гийгүүлэгч нь үгийн эхний дуугүй гийгүүлэгчийн дараа орохдоо авиа ондооших ёсоор дуутай болсон байна.

Үүнд: s > z [ɬ] ~ zh [dz] / # C₁ ([- voiced]) V·_VC

Жишээ нь:

chuzi [tʃuɬzi] (Mo. čisu, Kh. цус), khuzhu [quɖzu] (Mo. qosiγu, Kh. хошуу) гэх мэт.

⑤ Монгол бичгийн хэлний үгийн тэргүүн үеийн -o- эгшиг нь Миньхэ монгол хэлний үгийн нэгдүгээр үед уйтан эгшиг -u- болж тохиролцох нь олонтоо байна.

Жишээ нь:

tughuo [tuguo] (Mo. toγuγ-a, Kh. тогоо), chujin [tʃuɬʒin] (Mo. jočín, Kh. зочин), nughuai [nuɣuai] (Mo. noqai, Kh. нохой), wulan [ulan] (Mo. olan, Kh. олон) гэх мэт.

⑥ Монгол бичгийн хэлний үгийн битүү үе нь Миньхэ монгол хэлэнд ер нь задгай үе

болох хандлагатай байна. Битүү үеийг задгай үе болгоход дэвсгэр үсэг дээр эгшиг нэмэх арга бий.

Үүнд: # (C)VC·> # (C)V·CV·

Жишээ нь:

qijighe [tɛidʒigə] (Mo. čečeg, Kh. цэцэг), buleghe [buləgə] (Mo. bulay, Kh. булаг) гэх мэт.

Үгийн бүтцийнх нь талаар авч үзвэл *боорцог* гэдэг үг нь *боов* “гурилан идээ” гэсэн үгэнд “тухайн үндсэн утга шинж бүхий” нэрээс нэр бүтээх *-caɣ*⁴ (~ *-цаг*⁴) дагавар залгаж бүтсэн хэлбэр буюу *боов* гэсэн үгийн *үүсмэл үг* гэж үзэж байна.

Үүнд: Ярианы хэлэнд **bōbu* (боов, Mo. boubu)-*say* (-caɣ, Mo. -say ~ -suɣ) > **bōbsog* (үеийн төгсгөлийн *-b* нь *-r* болсон)⁷⁾ > *bōrsog* ([bɔ:rsəɣ], Mo. boɣursuɣ) > Kh. боорцог [bɔ:rtɕəɣ]⁸⁾ гэх мэтээр, бас тус үгийн монгол бичгийн хэлбэр нь **boɣūbu-say* > **boɣūb-say* > **boɣūr-say* > Mo. boɣursuɣ гэх үе шат дамжиж үүссэн бололтой.

1.3 mugha [mugɑ] “meat” (Kh. мах, Mo. miq-a)

Энэхүү үг нь орчин цагийн монгол хэлний “мах” гэсэн утгатай бөгөөд авианы хувьслын үүднээс үзэхэд доорх мэтээр хувирч ирсэн гэж үзэж байна.

Үүнд: **miqɑ* (① нэгдүгээр үеийн эгшиг *i* нь *a* болсон) > **maqɑ* > **maɣɑ* (② нэгдүгээр үеийн эгшиг *a* нь *u* болсон) > *mugɑ*

Энэ явцад тохиолдсон авианы үзэгдлийг үүссэн дарааллаар товчхон тайлбарлая.

① Монгол бичгийн хэлний нэгдүгээр үеийн эгшиг *i* нь хоёрдугаар үеийн эгшигтэй ижилшин хувьсахыг “*i*-гийн нугарал” гэдэг. Үүнийг дотор нь “*i*-гийн бүрэн нугарал”, “*i*-гийн бүрэн бус нугарал” гэж хоёр хувааж болох ба эхнийх нь хожим *i*-гийн ул мөр огт мэдэгдэхгүй болсныг, сүүлийнх нь *i*-гийн ул мөр хадгалагдаж байгааг хэлдэг.

А. “*i*-гийн бүрэн нугарал”-ийн жишээ:

Mo. *nidü*, Kh. нүд [nud] / Mo. *kituɣ-a*, Kh. хутга [χutäc] / Mo. *čisu*, Kh. цус [tsus] / Mo. *jɣasu*, Kh. загас [dʒaɣäs] гэх мэт.

В. “*i*-гийн бүрэн бус нугарал”-ийн жишээ:

Mo. *mingɣ-a*, Kh. мянга [mjaŋɣa] / Mo. *nɪlq-a*, Kh. нялх [njalχ] / Mo. *kiɣa-*, Kh. хярга- [χjaɣa-] / Mo. *čidal*, Kh. чадал [ʧadäl] / Mo. *jida*, Kh. жад [dʒad] гэх мэт.

Энэ байдлаас үзэхэд дээрх **miqɑ* > **maqɑ* болсон нь “*i*-гийн бүрэн нугарал” гэж болно.

② Монгол бичгийн хэлний нэгдүгээр үеийн *-a-*, *-i-* эгшиг нь үгийн эхний хоёр уруулын *m-* гийгүүлэгчийн дараа орохдоо Миньхэ монгол хэлэнд уруулын эгшиг *-u-* болох тохиолдол нэлээн байдаг⁹⁾.

Үүнд: *a, i* → *u* / # *m* _·

Жишээ нь:

mughashi [mugɑʃi] (Mo. *maɣyasi*, Kh. маргааш), *muni* [muni] (Mo. *minü*, Kh. миний)

Дүгнэж хэлэхэд Миньхэ монгол хэлний энэхүү *mugha* [mugɑ] гэдэг үг нь ч энэхүү дүрмийг дагаж, **miqɑ* > **maqɑ* > **maɣɑ* > *mugɑ* гэх мэтээр хувьсаж ирсэн буй за.

1.4 jierghasi [d͡ziə-ɡasi] “fish” (Kh. загас, Mo. jiyasu)

Энэхүү үг нь орчин цагийн монгол хэлний “загас” гэсэн утгатай бөгөөд авианы хувьслын үүднээс үзэхэд дараах байдлаар хувирч ирсэн гэж үзэж байна.

Үүнд: *jilgasun (① Миньхэ монгол хэлний өмнөх хэлний шатанд үеийн төгсгөлийн *-l-тэй байж, ② тэр нь -r- болсон) > *jirgasu > jierghasi [d͡ziə-ɡasi]

Энэ явцад тохиолдсон авианы үзэгдэл гэвэл:

① Тус үгийн монгол бичгийн хэл, дундад үеийн монгол хэлний хэлбэрийг тус тус Mo. jiyasu(n), MMo. jigasun, jigasun (只合速、只合孫) гэдэг боловч монгол төрөл хэлний нэг болох Баоань хэлний *d͡zalgasən* гэсэн хэлбэрийг харгалзан үзвэл энэхүү үг нь Миньхэ монгол хэлний өмнөх хэлний шатанд үеийнх нь төгсгөлд *-l- гийгүүлэгчтэй байсан буюу *jilgasu гэсэн хэлбэртэй байсан гэж таамаглаж болох байна.

② Монгол бичгийн хэлний үе буюу үгийн адагт орсон -l- гийгүүлэгч нь Миньхэ монгол хэлэнд -r- болж, -er- [ə] дуудлагатай болсон байна.

Үүнд #...CV*l· > #...CVr·

Жишээ нь:

dier [diə] (Mo. *debel* ~ *degel*, Kh. дээл), gher [gə] (Mo. *yal*, Kh. гал), xier [çiə] (Mo. *segül*, Kh. сүүл), ghuder [gudə] (Mo. *qudal*, Kh. худал), wuguer [uguə] (Mo. *ebül*, Kh. өвөл), erjige [ə-d͡ʒigə] (Mo. *eljige*, Kh. илжиг), erda- [ə-da-] (Mo. *alda-*, Kh. алда-), khuer- [quə-] “арьс ~” (Mo. *qayul-*, Kh. хуул-) гэх мэт.


Давтан хэлэхэд Миньхэ монгол хэл, Баоань хэлэнд үгийн дунд -l- (> -r-) гийгүүлэгчтэй, монгол бичгийн хэл, дундад үеийн монгол хэл болон Хүжү монгол хэлэнд -l- гийгүүлэгчгүй (cf. Хүжү монгол хэл *jaghasi* [d͡zagasɪ]) байна.

Түүнээс гадна эрт ба дундад үеийн монгол хэлний үгийн эцсийн *-sun / *-sün бүтээврийн өмнө монгол бичгийн хэлэнд огт байдаггүй хажуугийн гийгүүлэгч *-l- тохиолддог.

Жишээ нь: Mo. *čayasu(n)*, Kh. цаас / *čacā/sun > MMo. *ča’ālsun*, Mo. *mösü(n)*, Kh. мөс / *möl/sün > MMo. *mölsün* гэх мэтийн үгэнд тохиолддог *-l-sun / *-l-sün гэсэн хэлбэрийг үндэс болгож, тус үгийн анхны хэлбэрийг *jigalsun гэж таамаглаж байна.

Дээрх саналыг дагавал энэхүү үгийн авианы хувьслыг дараах байдлаар тайлбарлах нь хамгийн боломжтой байна.

Үүнд: *jigalsun (-l- авиа гээгдсэн) > *jigasun



1.5 ghuru [guru] “flour” (Kh. гурил, Mo. үлir)

Энэхүү үг нь орчин цагийн монгол хэлний “гурил” гэсэн утгатай бөгөөд авианы хувьслын үүднээс үзэхэд доорх мэтээр хувирч ирсэн гэж үзэж байна.

Үүнд: *gulir (① *l*-, *r*- хоёр гийгүүлэгч тонгорсон) > *guril (② үгийн төгсгөлийн гийгүүлэгч -*l* гээгдсэн) > ghuru [guru]

Энэ явцад тохиолдсон авианы үзэгдэл гэвэл:

① Монгол бичгийн хэлний Mo. үлir гэсэн үгийг үндэслэж, анхны хэлбэрийг нь *gulir мөн гэж үзвэл Миньхэ монгол хэлний хэлбэр нь эхлээд хоёр гийгүүлэгч *l*-, *r*- тонгорч, *gulir гэдгээс *guril болсон нь лавтай буй за¹⁰. Монгол төрөл хэлний хүрээнд энэхүү үгийн гарлыг хөөж үзсэнээр *gulir гэж хэлдэг бүлэг, *guril гэж хэлдэг бүлэг гэж хоёр хувааж болох бөгөөд Миньхэ монгол хэл сүүлийнх нь бүлэгт хамаарна.

② Монгол бичгийн хэлний үе буюу үгийн адагт орсон гийгүүлэгч, өөрөөр хэлбэл хатуу дэвсгэр -*l* нь Миньхэ монгол хэлэнд ихэнхдээ бүрэн гээгдэх дүрэмтэй байдаг. Энэ нь монгол бичгийн хэлний үгийн битүү үе нь Миньхэ монгол хэлэнд ер нь задгай үе болдог хандлагатай холбоотой юм.


Үүнд: #...CV_ / -*l* > Ø

Жишээ нь:

arigha- [ariga-] (Mo. ari/ya-, Kh. арилга-), ayou [ɑjou] (Mo. ayul, Kh. аюул), chiber [tʃibə-] (Mo. ki/bar, Kh. хялбар), tai- [tai-] “хувцас ~” (Mo. tayil-, Kh. тайл-) гэх мэт.

Монгол төрөл хэлний хүрээнд авч үзвэл энэхүү үгийн авианы хувьслыг дараах байдлаар тайлбарлаж болох байна.

Үүнд: *gulir бүлэг (-*l*-, -*g*- хоёр авиа тонгорсон)



1.6 budi [budi] “wheat” (Kh. буудай, Mo. buyudai)

Энэхүү үг нь орчин цагийн монгол хэлний “буудай” гэсэн утгатай бөгөөд авианы хувьслын үүднээс дараах байдлаар хувирч ирсэн гэж үзэж байна.

Үүнд: *bugūdai > *būdai (① урт эгшиг -*ui* нь богино эгшиг -*u* болж, ② үгийн төгсгөлийн хос эгшиг -*ai* нь -*i* болсон) > budi [budi]

Энэ явцад тохиолдсон гол авианы үзэгдэл гэвэл:

① Орчин цагийн монгол хэлний урт эгшиг нь Миньхэ монгол хэлэнд голдуу богино эгшиг, хааяа хос эгшиг болсон бөгөөд цуваа цагийн үүднээс үзэхэд Миньхэ монгол хэлэнд урт эгшиг нь богиносож, урт богино эгшгийн ялгаа байхгүй болсон байна.

Жишээ нь:

*aḡūla > a'ūla > ūla > ula (Миньхэ монгол: wula [ula] / Mo. ayula, Kh. уул)

*quriyā- > qurā- > qura- (Миньхэ монгол: khura- [qura-] / Mo. quriya-, Kh. хураа-)

*eḡūde > e'ūde > ūde > ude ~ ide > idi (Миньхэ монгол: yidi [idi] / Mo. eḡūde, Kh. үүд)

*bögēsü > bö'ēsü > bösü > bosı (Миньхэ монгол: bosı [bosı] / Mo. bögesü, Kh. бөөс) гэх мэт.

Монгол төрөл хэлний хүрээнд авч үзвэл энэхүү үгийн авианы хувьслыг дараах байдлаар тайлбарлаж болох байна.

② Монгол бичгийн хэлний хос эгшиг *-ai* нь Миньхэ монгол хэлэнд ер нь *ai-* [ai-] эгшиг хэвээрээ сайн хадгалагдсан байдаг.


Жишээ нь:

kheghai [qəcai] (Mo. yaqai, Kh. гахай), nughuai [nuguai] (Mo. noqai, Kh. нохой), moghai [mogai] (Mo. moyai, Kh. могой), taolai [taolai] (Mo. tulai, Kh. туулай) гэх мэт.

Энэ байдлаас үзэхэд хос эгшиг *-ai* нь *-i* болох нь дээрх дүрмийг дагахгүй гажсан хэлбэр бөгөөд эргэн тойрны хэл болох Баоань хэл: bөгdi, Канжаа хэл: бэгdi ~ багdi, Хүжү монгол хэл: buudi гэсэн *-i* төгсгөлтэй хэлний нөлөө туссан ч байж мэдэх юм.

Монгол төрөл хэлний хүрээнд авч үзвэл энэхүү үгийн авианы хувьслыг дараах байдлаар тайлбарлаж болох байна.

Үүнд: *bucū dai > *bu'ūdai > *būdai > *budai



1.7 suzu [sudzu] “water” (Kh. yc, Mo. usu)

Энэхүү үг нь орчин цагийн монгол хэлний “ус” гэсэн утгатай бөгөөд авианы хувьслын үүднээс дараах байдлаар хувирч ирсэн гэж үзэж байна.

Үүнд: *husu (① үгийн эхний *h-* гийгүүлэгч нь *sh-* болсон) > *shusu (② үгийн хоёрдугаар үеийн *-s* нь *-z* болсон) > *shuzu (③ үгийн эхний *sh-* гийгүүлэгч нь *s-* болсон) > suzu [sudzu]

Энэ явцад тохиолдсон авианы үзэгдэл гэвэл:

① Үгийн эхний (дундад зууны монгол хэлний) **h-* гийгүүлэгч нь голдуу тэр чигээрээ хадгалагдсан байхад тус гийгүүлэгчээс өөр *sh-* гийгүүлэгчтэй тохиролцох нь бий.

Үүнд: # h- > # h [x]-, sh [ʃ]- гэх мэт.

Жишээ нь:

huotu [xuotu] (Mo. (h)odu, Kh. од), huang [xuaŋ] (Mo. (h)on, Kh. он),
 hulang [xulaŋ] (Mo. (h)ulayan, Kh. улаан), hongghu- [xoŋgu-] (Mo. (h)ungya-, Kh. унга-),
 huguer [xuguə] (Mo. (h)üker, Kh. үхэр), hunisi [xunisi] (Mo. (h)ünesü, Kh. үнс) гэх мэт.
 / shuda [ʃuda] (Mo. (h)uyuta, Kh. уут), shuduer [ʃuduə] (Mo. (h)urtu, Kh. урт),
 shidie [ʃidiə] (Mo. (h)erte, Kh. эрт), shini- [ʃini-] (Mo. (h)iniye-, Kh. инээ-) гэх мэт.

② Үгийн хоёрдугаар үеийн эхний дуугүй гийгүүлэгч *-s* нь үгийн эхний дуугүй гийгүүлэгчийн дараа орохдоо авиа ондооших ёсоор дуутай *-z* болсон байна.

Үүнд: s > z [dʒ] ~ zh [dz] / # C₁ ([– voiced]) V·_VC


Жишээ нь:

chuzi [tʃudzi] (цус, Mo. čisu), khuzhu [qudzu] (хошуу, Mo. qosiyu) гэх мэт.

③ Үгийн эхний *sh-* гийгүүлэгч нь *s-* болсон үзэгдлийг үгийн эхний “тагнайшсан гийгүүлэгч” *sh-* [ʃ]-гийн дараа хоёрдугаар үеийн эхний “эс тагнайшсан гийгүүлэгч” *-z* [ʒ] орохоор “тагнайшсан гийгүүлэгч” *sh-* [ʃ] нь авиа ижилших ёсоор “эс тагнайшсан гийгүүлэгч” *s-* [s] болсон гэж тайлбарлаж болох юм¹²⁾.

Үүнд: *sh-* (тагнайшсан) + *-z* (эс тагнайшсан) > *s-* (эс тагнайшсан) + *-z* (эс тагнайшсан)

Монгол төрөл хэлний хүрээнд авч үзвэл энэхүү үгийн авианы хувьслыг дараах байдлаар тайлбарлаж болох байна.



2. Утгын хувьслын үүднээс үзэх нь

1-р бүлэгт Миньхэ монгол хэлний идээ ундааны зарим нэрийг авианы хувьслын үүднээс үзсэн байхад энд утгынх нь хувьслын үүднээс авч үзье.

2.1 yama [jama] “food” (Kh. юм, Mo. yaɣum-a)

Энэхүү үг нь хэлбэрийн хувьд авч үзвэл орчин цагийн монгол хэлний “ямар нэгэн зүйл (thing)” гэсэн утгатай юм гэсэн үг юм.

Монгол төрөл хэлний дотор, ялангуяа Миньхэ монгол хэлний эргэн тойрны цөөнх үндэстний хэлэн дэх тус үгийн утгыг үзүүлбэл доорх мэт:

А. Бичгийн хэлний жишээ:

Mo. yaɣum-a “thing”, Тод бичиг: yumun “thing”

В. Ярианы хэлний жишээ:

Баоань: jama “thing”

Дуншаан: jama “thing”

Канжаа: jama “something”

Миньхэ монгол: jama “food”¹⁴⁾

Хүжү монгол: юм гэсэнд таарах монгол гаралтай үг байхгүй. cf. dŋɕei (< Ch. 东西 dongxi) Зүүн ёгор: jima “thing”

Энэ байдлаас үзэхэд Миньхэ монгол хэлний энэхүү үгийн утга “food” (хоол) гэдэг нь нэлээн өвөрмөц утгатай бөгөөд цуваа цагийн үүднээс үзэхэд “юм (thing)” > “идэх юм (something to eat)” > “хоол (food)” гэх мэтээр хувьсаж ирсэн байх гэж үзэж байна. Үүнийг хэл шинжлэлийн талаар үзэхэд утга нь явцуурсан буюу англиар “narrowing (specialization, or restriction of meaning)” гэж тайлбарлаж болох юм.

Миньхэ монгол хэлэнд жишээлбэл: yama di- [jama di-] (хоол идэ-), yama china- [jama

tʃina-] (хоол хий-) гэх зэргээр хэрэглэгдэнэ.

2.2 buda [buda] “noodles” (Kh. будаа, Mo. buday-a)

Энэхүү үг нь хэлбэрийн хувьд авч үзвэл орчин цагийн монгол хэлний “амуу тарианы ерөнхий нэр, тариа будаа” гэсэн утгатай *будаа* гэсэн үг юм¹⁵⁾.

Монгол төрөл хэлэн дэх тус үгийн утгыг үзүүлбэл доорх мэт:

А. Бичгийн хэлний жишээ:

Mo. *buday-a* “grain, cereals”, ММо. *buda’ān* “rice porridge”, Тод бичиг: *budān* “food”

В. Ярианы хэлний жишээ:

Kh. будаа “1. grain, cereals (амуу тариа), 2. rice (цагаан будаа)”

Өвөр монгол: [buda:] ~ [bada:] “1. food, 2. grain, cereals”

Дуншаан: *budaŋ* “food”

Канжаа: *budo* “food, noodles”

Миньхэ монгол: *buda* “noodles”

Хүжү монгол: *budaa* “food”

Зүүн ёгор: *bada:n xula* “noodles” (cf. *xula* “food”)

Дагуур: *buda:* “food”

Энэ байдлаас үзэхэд Миньхэ монгол хэлний энэхүү үгийн утга “noodles” (гурилтай хоол) гэдэг нь Канжаа хэл, Зүүн ёгор хэлэнд ч гэсэн нэгэн адил тусгагдсан байна. Цуваа цагийн үүднээс үзэхэд “амуу тариа (grain, cereals)” > “хоол (food)” > “гурилтай хоол (noodles)” гэх мэтээр хувьсаж ирсэн байх гэж үзэж байна.

Үүнийг хэл шинжлэлийн талаар үзэхэд эхлээд “амуу тариа (grain, cereals)” гэсэн утгаас “хоол (food)” болсон нь утга өргөжсөн буюу англиар “broadening (generalization, or extension of meaning)”, дараа нь “хоол (food)” гэсэн утгаас “гурилтай хоол (noodles)” болсон нь утга явцуурсан буюу англиар “narrowing (specialization, or restriction of meaning)” гэж тайлбарлаж болох юм.

Миньхэ монгол хэлний энэхүү утгын хувьсал нь Миньхэ монголчуудын уламжлалт хоол нь “гурилтай хоол (noodles)” болохыг тусгаж байгаа хэрэг юм.

2.3 amula [amula] “fruit” (Kh. алим, Mo. alim-a)

Энэхүү үг нь хэлбэрийн хувьд авч үзвэл орчин цагийн монгол хэлний “шүүслэг амттай жимс (apple)” гэсэн утгатай *алим* гэсэн үг юм¹⁶⁾.

Монгол төрөл хэлэн дэх тус үгийн утгыг доор үзүүлье.

А. Бичгийн хэлний жишээ:

Mo. *alim-a* “apple”, ММо. *alima* (阿里麻) “梨 pear”, Тод бичиг: *aliman* “梨 pear”

В. Ярианы хэлний жишээ:

Kh. алим “apple”¹⁷⁾

Өвөр монгол: [ælim] “pear”

Ойрад: [ælmen] “pear”

Баоань: *alma* “fruit, apricot”

Дуншаан: *alima* “fruit, pear”

Канжаа: *alima* “fruit”

Миньхэ монгор: *amula* “fruit”

Хүжү монгор: *alima* “fruit, pear”

Зүүн ёгор: *alma* “fruit”

Дагуур: *alim* “pear”

Миньхэ монгор хэлний энэхүү үг нь авианзүйн үүднээс *l-m* хоёр гийгүүлэгч тонгорсноос **alima* > **aluma* > *amula* гэх мэтээр хувьсаж ирсэн нь лавтай бөгөөд утгын хувьд “pear” гэсэн уг утгаас “fruit (жимс)” гэсэн утгатай болсон нь хэл шинжлэлийн талаар үзэхэд утга нь өргөжсөн буюу англиар “broadening (generalization, or extension of meaning)” гэж тайлбарлаж болох юм.

Ташрамд хэлэхэд орчин цагийн монгол хэлний “fruit” гэсэн утгатай *жимс* (Mo. *jimis*) гэдэг нь Түрэг гаралтай үг (Tur. *ye-* “eat” → *yemiš* “fruit” < **jemiš* > Mo. *jimis*) мөн бөгөөд дундад үеийн монгол хэлний сурвалж бичиг болох *Мукаддимат Ал-Адаб* тольд *jimiš*, *Хуа-И и юй* (華夷譯語) тольд 者迷失 *jemiš(i)* 《果》 гэж гардаг. Бас дээр дурдсан монгол төрөл хэлний цөөнх үндэстний хэлнүүдэд, ялангуяа “fruit” гэсэн утга илэрхийлдэг ямар ч хэлэнд (Баоань хэлнээс авахуулаад Зүүн ёгор хэл хүртэл, дээр нь Дагуур хэлэнд ч мөн) Mo. *jimis* гэсэн үгэнд таарах үг батлагдаагүй байна.

2.4 *durasi* “liquor” (Kh. дарс, Mo. *darasu*)

Энэхүү үг нь хэлбэрийн хувьд авч үзвэл орчин цагийн монгол хэлний “жимсний архи葡萄酒” гэсэн утгатай *дарс* гэсэн үг юм.

Монгол төрөл хэлэн дэх тус үгийн утгыг үзүүлбэл доорх мэт:

A. Бичгийн хэлний жишээ:

Mo. *ariki* (~ *araki*) “liquor” / *darasu(n)* “wine”, MMo. — / *darasun* (荅𠵿刺孫) “酒 liquor”

Тод бичиг: *arki* “酒 liquor” / —

B. Ярианы хэлний жишээ:

Kh. архи “liquor” / дарс “wine”

Өвөр монгол: [ærx] “酒 liquor” / [dars] “黄酒 rice wine, 酒 liquor”

Ойрад: [ærke] “酒 liquor” / [darsn] “黄酒 rice wine, 酒 liquor”

Баоань: *rakə* “酒 liquor” / —

Дуншаан: — / *darasuŋ* “酒 liquor”

Канжаа: — / *dərasun* ~ *drasun* “酒 liquor”

Миньхэ монгор: — / *durasi* [durasi] “酒 liquor”

Хүжү монгор: — / *duraasi* “酒 liquor”

Зүүн ёгор: *arəkə* “酒 liquor” / —


Дагуур: *arγ* “酒 liquor” / *arγ dars* “酒 liquor”

Монгол бичгийн хэлний *ariki* гэдэг үг нь араб гаралтай *عرق* ‘*araq* (> Түрэг: *rakī*) гэсэн үгээс 13, 14-р зууны үед орсон харь үг мөн бөгөөд ‘*araq* > *araki* > *ariki* гэх мэтээр

хувьсаж ирсэн бололтой. Харин *darasu(n)* гэдэг нь *дарсан юм* (Mo. *daru-γsan yaγum-a*) буюу “удаан хугацаанд хадгалж, нөөцөлсөн архи” гэсэн утга бүхий, монгол гаралтай нийлмэл үгийн хураагдсан хэлбэр гэж болно.

Дундад үеийн монгол хэлний сурвалж бичиг болох *Монголын нууц товчоо* болон *Хуа-И и юй* (華夷譯語)-д *darasun* (荅剌孫)¹⁸⁾ “酒 liquor” гэж гарахаас гадна, *araki* (> *ariki*) гэсэн үг нь 1330 онд хятад хэлээр зохиогдсон монгол хоолны тухай *Жэньшань Жэньяо* (飲膳正要)¹⁹⁾ гэсэн номд анх “阿剌吉 (*araki*) 酒” гэж гарсан бөгөөд тэр нь ислам шашинтай орноос орж ирсэн “нэрсэн архи”-ийг хэлдэг гэж тэмдэглэсэн ажээ²⁰⁾.

Дээрх байдлаас үзэхэд монгол төрөл хэлэн дэх энэ хоёр үгийн тархац болон утгын хувьслыг үзүүлбэл дараах байдалтай.



Цуваа цагийн үүднээс үзэхэд орчин цагийн монгол хэлний халхын аялгуун дахь *дарс* гэдгийн “wine (жимсний архи)” гэсэн утга нь тус үгийн уг утга “*liquor (in general)* (архины ерөнхий нэр)” гэдгээс хувьсаж ирсэн бөгөөд үүнийг хэл шинжлэлийн талаар үзэхэд утга нь явцуурсан буюу ангиар “narrowing (specialization, or restriction of meaning)” гэж тайлбарлаж болох юм²¹⁾.

Харин Миньхэ монгол хэлний тус үгийн утга “酒 liquor” гэдэг нь эргэн тойрных нь хэл болох Дуншаан хэл, Канжаа хэл, Хүжү монгол хэлтэй нэгэн адил, дундад үеийн монгол хэлний уг утгаа тэр чигээр нь баттай хадгалсаар иржээ гэж дүгнэж болох байна.

3. Дүгнэлт

Миньхэ монгол хэлэн дэх идээ ундааны зарим нэрийн тухай дурдахдаа хэлний авианы хувьсал, утгын хувьсал гэсэн хоёр үүднээс тусгайлан авч дээр тодорхойлсон билээ.

Авианы хувьслын үүднээс: *dimei* “bread”, *puzuoghuo* “fried piece of dough”, *mugha* “meat”, *jierghasi* “fish”, *ghuru* “flour”, *budi* “wheat”, *suzu* “water” гэсэн долоон үгийг, бас

утгын хувьслын үүднээс: *yama* “food”, *buda* “noodles”, *amula* “fruit”, *durasi* “liquor” гэсэн дөрвөн үгийг, нийтдээ 11 үгийг авч үзлээ.

Судалгааны дүнд дараах зүйлийг тодруулсан болно.

3.1 Авианы хувьслын үүднээс үзэхэд:

Дээр 1-р бүлэгт дурдсан Миньхэ монгол хэлний тус долоон үгийн авианы байдлыг монгол бичгийн хэл, дундад үеийн монгол хэл, орчин цагийн монгол хэл болон бусад монгол төрөл хэл аялгуунуудын байдалтай харьцуулан үзсэний дүнд а. *Үгийн эхний гийгүүлэгч, мөн үе болон үгийн адагт орсон гийгүүлэгч гээгдсэн*, б. *Урт эгшиг нь богино эгшиг эсвэл хос эгшиг болсон*, с. *Үгийн эхний дуутай гийгүүлэгч нь дуугүй болж, хоёрдугаар үеийн дуугүй гийгүүлэгч нь дуутай болсон*, d. *Гийгүүлэгч авиа тонгорсон*, e. *Зарим үгийн дунд болон үеийн төгсгөлд орсон эртний монгол хэлний *l (> r) гийгүүлэгчийг хадгалсан* гэх мэт авианы хувьслын үзэгдэл байгааг ажиглалаа.

3.2 Утгын хувьслын үүднээс үзэхэд:

Бас 2-р бүлэгт дурдсан Миньхэ монгол хэлний тус дөрвөн үгийн утгыг монгол бичгийн хэл, дундад үеийн монгол хэл, орчин цагийн монгол хэл болон бусад монгол төрөл хэл аялгуунуудын утгатай харьцуулан үзсэний дүнд а. *Утга нь явцуурсан* (Eng. *narrowing (specialization, or restriction of meaning)*), б. *Утга нь өргөжсөн* (Eng. *broadening (generalization, or extension of meaning)*) гэсэн утгын хувьслын хоёр үзэгдэл байгаа нь ажиглагдаж байна. Ташрамд хэлэхэд орчин цагийн монгол хэлний халхын аялгуун дахь үгийн утгыг гол болгож үзвэл Миньхэ монгол хэлний үгийн утга нь өргөжсөн гэмээр санагдавч үнэндээ тийм биш, уугуул утгаа хадгалсаар байгаа бололтой.

4. Төгсгөл

Миньхэ монгол хэл нь орчин цагийн “монгол хэлний төв аялгуунууд” гэгддэг Монгол (Халх, Өвөр монгол), Халимаг, Буриад зэрэг хэлнүүдээс нэлээн зайдуу өмөрмөц онцлогтой, монгол төрөл хэлний салангид хэл юм.

Идэж уух явдал нь хүний өдөр тутмын амьдралын үндсэн үйлийн нэг юм. Тиймээс энэ удаа Миньхэ монгол хэлний “идээ ундааны нэр”-ийг бүгдийг нь биш ч, заримаас нь тусгайлан авч дурдах нь цуваа цагийн үүднээс тус хэлний авиа болон утгын хувьслыг мэдэж авах нэг үлгэр жишээ болж чадна гэж үзсэн билээ.

Ер нь ямар ч хэлний үг бүр өөрийн гэсэн түүхтэй байдаг. Мөн ямар ч хэлэнд эртнээс уламжлагдаж ирсэн зүйл, шинэчлэгдсэн зүйл гэж байдаг. Иймд тус хэлний цуваа цагийн судалгааг нарийвчлан явуулах нь нэн чухал гэж үзэж байна.

ЗҮҮЛТ

- 1) Монгол хэлний халхын аялгуу, монгол бичгийн хэлийг тус тус Kh., Mo. гэж товчлов.
- 2) *Чжи Юань и юй* (至元譯語, 1325) дээрх монгол хэлний нэг онцлог нь хятад үсгээр монгол бичгийн хэлний хатуу дэвсгэр үсгийн заримыг нь нарийн зөв галиглаж чадаагүй байсан бололтой. Жишээ нь: 忽都 *qudu* 《井》(Mo. qudduy / Kh. худар), 忽耶 *quya* 《甲》(Mo. quaya / Kh. хуяг) гэх мэт.
- 3) Түрэг хэлийг Tug. гэж товчлов.
- 4) Дундад үеийн монгол хэлийг MMo. гэж товчлов.
- 5) Халимаг хэлийг Kalm. гэж товчилсон бөгөөд халимаг хэлнээс бусад ойрад аялгуунд, жишээ нь Хятад улсын Шинжаан орон, Хөхнуур муж, Өвөр Монголын Алшаа аймаг, Монгол улсын баруун нутгийн аль алинд нь ч энэхүү MMo. *üdmeg* гэсэн хэлбэрийн үл мөр харагдахгүй байна.
- 6) Монгол төрөл хэл (Mongolic languages)-ийг Mong. гэж товчлов. Түрэг хэлний *ekmek* “bread (талх)” гэдэг үгээс дундад зууны монгол хэлэнд орохдоо *üdmeg* болж хувирсан бөгөөд үгийн эхний эгшиг *e-* ~ *ü-* сэлгэсэн нь ажиглагдавч яагаад уруулын бус эгшиг *e-* нь уруулын эгшиг *ü-* болсон тухай тодорхойгүй байна.
- 7) Монгол бичгийн хэлний үеийн төгсгөлийн *-b*, *-ү*, *-g* гэх мэтийн хатуу дэвсгэр нь *-r* болж хувьсах нь ялангуяа Дагуур (Dag.) хэлэнд элбэг тохиолдож байна. Жишээ нь: Mo. *nabči* (навч), Dag. *larʃ* / Mo. *tobči* (товч), Dag. *torʃ* / Mo. *ebde-* (эвдэ-), Dag. *ərd-* / Mo. *kebte-* (хэвтэ-), Dag. *kərt-* / Mo. *bulay* (булаг), Dag. *bula:r* / Mo. *qudduy* (худар), Dag. *kodir* / Mo. *elbeg* (элбэг), Dag. *əlpur* гэх мэт.
- 8) Халхын аялгуунд боорцог [bɔ:ɮsɔɣ] гэдэг байхад Өвөр Монголын ихэнх аялгуунд [bɔ:rsɔɣ] гэдэг бөгөөд өнгөцхөн харахад хамжин шүргэх [ɮ], шүргэх [s] авиа нь хоёр нутгийн аялгууны ялгааг харуулж байгаа боловч үнэндээ Mo. *boɣursuɣ* (< *boɣūr-saɣ < *boɣūb-saɣ < *boɣūbu-saɣ) хэлбэрийг үндэслэвэл нэрээс нэр бүтээх үгийн *-saɣ* дагаврыг халхын аялгуунд *-цаг*⁴ (Mo. *-ᠴaɣ* ~ *-ᠴuɣ*) хэлбэрээр орлосон боломж их байна. Халхын аялгуунд нэрээс нэр бүтээх *-caɣ*⁴ дагавар нь ер нь “тухайн юманд дур хүсэлтэй” гэсэн утгыг илэрхийлдэг байхад *-цаг*⁴ дагавар нь “тухайн юмны холбогдол бүхий шинж чанартай” гэсэн утгыг илэрхийлдгийг харгалзан үзвэл *боов*, *боорцог* хоёр үгийн харьцаа сүүлийн утгатай нь лавтай буй за. Жишээ нь: *цайсаг* (< *цай*), *махсаг* (< *мах*); *довцог* (< *дов*), *бөмбөрцөг* (< *бөмбөр*) гэх мэт.
- 9) Монгол бичгийн хэлний нэгдүгээр үеийн *-a-*, *-i-* эгшиг нь үгийн эхний хоёр уруулын *m*-гийгүүлэгчээс гадна, бас *b-* гийгүүлэгчийн дараа ч Миньхэ монгол хэлэнд уруулын эгшиг *-u-* болох тохиолдол байдгийг дурдууштай байна. Жишээ нь: *bura-* [bura-] “хүн үхэ-” (Mo. *bara-*, Kh. *бара-*), *buliu* [buliu] (Mo. *bilegüü*, Kh. *билүү*) гэх мэт. Харин *b-*, *m-*ээр эхлэх дан үетэй үгэнд ийм хувьсал гараагүй байна. Жишээ нь: *bi* [bi] (Mo. *bi*, Kh. *би*), *bi* [bi] (Mo. *bui*, Kh. *бий*, *буй*) / *ma* [ma] (Mo. *ba*, Kh. *ба* “бөгөөд”), *ma* [ma] (Mo. *mai*, Kh. *май* “аялга үг”) гэх мэт.
- 10) Монгол бичгийн хэлний хэлбэртэй харьцуулан үзэхэд Миньхэ монгол хэлний үгийн эхэнд нь ч бай дунд нь ч бай, дараалан орсон *l-r* гийгүүлэгчээс гадна, *n-d*, *r-t* гэх мэтийн “шүдний хоёр гийгүүлэгч” тонгорсон нь бий.

Жишээ нь:

$n-d > d-n$: Mo. nidonon, Kh. ноднин / **nida-hon* > **dani-hon* > Миньхэ: danihuang [danixuan]

$r-t > t-r$ (> d-r): Mo. (h)urtu, Kh. урт / **hurtu* > **hutur* > Миньхэ: shuduer [suduə]

- 11) Монгол бичгийн хэлний *buyudai* гэдэг үгэнд таарахуйц дундад үеийн монгол хэлний хэлбэр нь Монголын нууц товчоо-нд ер тохиолдоогүй боловч 1389 онд зохиогдсон *Хуа-И и юй* (華夷譯語) тольд 卜兀歹 *bu'udai* 《小麦》 гэсэн хэлбэрээр гарч байна.
- 12) Яг ижил биш ч гэсэн орчин цагийн монгол хэлэнд үгийн эхний *ц-, з-* гэх зэрэг “эс тагнайшсан гийгүүлэгч”-ийн дараа хоёрдугаар үеийн эхний *ч-, ж-, ш-* гэх зэрэг “тагнайшсан гийгүүлэгч” орохоор авиа ижилших ёсоор *ц-, з-* гэх зэрэг “эс тагнайшсан гийгүүлэгч” нь *ч-, ж-* гэх зэрэг “тагнайшсан гийгүүлэгч” болох үзэгдэл бий.
Үүнд: *ц-, з-* (эс тагнайшсан) + *ч-, ж-, ш-* (тагнайшсан) > *ч-, ж-* (тагнайшсан) + (тагнайшсан)
Жишээ нь:
цавчих > чавчих, цээж > чээж, цааш > чааш, зажлах > жажлах, завишаан > жавишаан, занчих > жанчих гэх мэт.
- 13) Монгол бичгийн хэлний Mo. usu(n) гэдгийн хамгийн эртний хэлбэрийг таамаглахдаа дундад үеийн ямар ч сурвалж бичигт үгийн эхний *h-* хэлбэртэй үг батлагдаагүй, *usun* (~ *usu*) гэж гардаг ч энд **husu(n)* гэж *h-* хэлбэртэй үзсэн болно. Үүнийг батлах учир шалтгаан нь монгол төрөл хэлний үүднээс үзэхэд: 1-рт Зүүн ёгор хэлний *qusun* дээр үгийн эхэнд *q-* хэлбэртэй байгаа, 2-рт Хүжү, Миньхэ хоёр монгол хэлний *szu, suzu* гэдгийн үгийн эхний гийгүүлэгчийг тайлбарлахдаа *s- < *sh- < *h-* гэдгээс хувьссан гэж үзэх нь хамгийн тохиромжтой, 3-рт Алтай овгийн хэлний үүднээс үзэхэд: солонгос хэлний “нуур” гэсэн утгатай үг нь *h-* хэлбэртэй 亨子 *hosu* гэж гардгийг үндэс болгож, хамгийн эртний хэлбэрийг нь **husu(n)* гэж таамаглаж байна. Ташрамд хэлэхэд О.Самбуудорж (2018:34) монгол хэлний *ус* гэсэн үгийг алтай овгийн хэлний үүднээс **husubun* ~ **husubun* гэж таамаглаж байгаа нь нэн сонирхолтой байна.
- 14) Миньхэ монгол хэлэнд *jama* гэвэл ер нь “хоол (food)” гэсэн утгатай боловч үгүйсгэсэн *guang* “үгүй, -гүй” хэлбэртэй хэрэглэгдэх үед буюу *jama guang* гэвэл “юмгүй” гэсэн утгатай, өөрөөр хэлбэл 1. “Яасан бэ?” гэдгийн хариуд нь “Яагаа ч үгүй, Гайгүй” гэсэн утгатай, 2. Мөн “Баярлалаа” гэдгийн хариуд нь “Зүгээр, Хамаагүй” гэсэн утгатай хэллэг болно. Энэхүү хэллэгт тохиолдож байгаа *jama* гэдэг нь “хоол (food)” гэсэн “шилжсэн утга” биш, “ямар нэгэн юм, юм (something, thing)” гэсэн “уг утга” буй за.
- 15) Орчин цагийн монгол хэлний халхын аялгуунд *будаа* гэвэл *цагаан будаа* гэсэн утгатай, өвөр монголын аман аялгууны [tutrāg] (тутарга) гэсэн үгтэй дүйдэг байхад харин өвөр монголын төв аялгууны [boda:] ~ [bada:] гэвэл халхын аялгууны *хоол* гэсэн утгатай болно.
- 16) Орчин цагийн монгол хэлний халхын аялгуунд *алим* гэвэл өвөр монголын төв аялгууны [almārād] гэсэн үгтэй дүйдэг байхад харин өвөр монголын төв аялгууны [ælim] гэвэл халхын аялгууны *лийр* гэсэн утгатай болно.
- 17) Орчин цагийн монгол хэлний халхын аялгуун дахь *алим* гэдэг үгийн “apple” гэсэн утга нь цуваа цагийн үүднээс үзэхэд “pear” гэсэн уг утгаас шилжсэн бололтой.
- 18) 14-р зууны үед араб үсгээр зохиогдсон *Ибн-Муханнын толь-д* бас *darasun* “вино” гэж тэмдэглэжээ.
- 19) (忽思慧 1993: 158, 267) гэсэн номоос үзнэ үү.

- 20) Ислам шашинтай орноос Монголд *araki* “архи” орж ирэхэд урьд нь Монголд байсан *darasu(n)* “дарс”-наас ялгарах утга нь юу вэ гэвэл “нэрж гаргасан ундаа”-г *araki*, “удаан хадгалж, нөөцөлсөн исгэсэн ундаа”-г *darasu(n)* гэдэг байсан байх гэж үзэж байна.
- 21) Халхын аялгууны *darс* гэдгийн утга (“葡萄酒 *wine*”) -ыг гол болгож үзвэл Миньхэ монгол хэлний гарал нэгтэй *durasi* гэдгийн утга (“酒 *liquor*”) нь “*wine* (жимсний архи)” гэдгээс “*liquor* (архины ерөнхий нэр)” болж хувьссан буюу утга нь өргөжсөн гэмээр санагдавч монгол төрөл хэлний хүрээнд цуваа цагийн үүднээс үзвэл үнэндээ тийм биш, түүний яг эсрэг үзэгдэл юм.

ТОВЧИЛСОН ҮГ

Mo. ∴ Монгол бичгийн хэл, MMo. ∴ Дундад үеийн монгол хэл, Mong. ∴ Монгол төрөл хэл, Kh. ∴ Халхын аялгуу, Kalm. ∴ Халимаг хэл, Dag. ∴ Дагуур хэл, Tur. ∴ Түрэг хэл, Eng. ∴ Англи хэл

НОМ ЗҮЙ

Dpal-Idan-bkra-shis, Keith.Slater, et al.

- 1996 *Language Materials of China's Monguor Minority: Huzhu Mongghul and Minhe Mangghuer*, Sino-Platonic Papers 69, University of Pennsylvania, Philadelphia.

忽思慧著、金世琳訳

- 1993 『薬膳の原典 飲膳正要』八坂書房、東京。

Jiang Genxiong

- 2018 “Language contact-based research on the evolution and development of the Minhe dialect of Monguor language”, 63-72, *Altai Hakpo* 28, The Altaic Society of Korea, Korea.

Самбуудорж, О.

- 2018 “Алтай овгийн хэлнүүдийн үгийн гарлыг фонемийн тоо буюу хэлэгдэх урт дээр нь үндэслэж харьцуулан судлах асуудалд”, *Altaica*, No.14, 23-41, Улаанбаатар.

Shiotani Shigeki

- 2019 *Grammar of Mangghuer*, The Research Institute for Languages and Cultures of Asia and Africa, Tokyo.

Шиотани Шигэки

- 2019 “Миньхэ монгол хэлний эгшиг авианы хувьсал хөгжлийг цуваа цагийн үүднээс судлах нь”, *Хэл зохиол судлал*, Vol.12 (44), 98-106, Улаанбаатар.

Шиотани Шигэки

- 2023 “Миньхэ монгол хэлний гийгүүлэгч авианы хувьсал хөгжлийг цуваа цагийн үүднээс судлах нь”, *Монгол хэл зохиол судлалын хөгжил, чиг хандлага (олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл)*, 146-157, Монгол улсын Шинжлэх ухааны академи, Хэл зохиолын хүрээлэн, Улаанбаатар.

Шиотани Шигэки

- 2023 “Миньхэ монгол хэлний үг бүтээх дагаврын судалгаа”, *Frontier of Foreign Language Education* 6, 21-38, Osaka.

Slater, Keith W.

2003a *A Grammar of Mangghuer: A Mongolic language of China's Qinghai-Gansu Sprachbund*, Curzon, London.

Slater, Keith W.

2003b “Mangghuer”: *The Mongolic Languages*, 307-324, Routledge, London and New York.

Тодаева Б.Х.

1973 *Монгорский язык: Исследование, тексты, словарь*, НАУКА, Москва.

ХАВСРАЛТ

Тус өгүүлэлд хэрэглэсэн “Миньхэ монгол хэлний латин үсэг” ба “Олон улсын авианы галиг” (ИРА)-ийн тохиролцоог доор үзүүлбэл:

1. Эгшиг

1.1 Богино эгшиг

a [a], o [o], u [u ~ y / ɛ, ʌ, ɔ-гийн дараа], e [ɛ], i [i ~ ɪ / s, ʌ, ɔ-гийн дараа]

1.2 Хос эгшиг

ai [ai], ei [ei], ao [ao], uo [uo], ou [ou], iu [iu], ie [ie], ue [ue], ua [ua], ia [ia]

1.3 Дараалсан гурван эгшиг

iao [iao], uai [uai]

2. Гийгүүлэгч

b [b], p [p], m [m], w [w], d [d], t [t], z [dz], c [ts], s [s], n [n], l [l], r [r], zh [dz], ch [tʃ], sh [ʃ],
j [dʒ], q [tʃ], x [x], y [j], g [g], k [k], h [x], ng [ŋ], gh [ɣ], kh [q]

3. Бусад анхаарууштай дуудлага

en [ɛn ~ m ~ n], er [ɛr], wu [u], si [si], ci [tsi], zi [dzi], xu [ɣy], qu [tɕy], ju [dʒy]